# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 11 өдөр Дугаар А/42.

Улаанбаатар хот

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Олон улсын атомын энергийн агентлагаас хандивласан нийт 14,146,233.85 (арван дөрвөн сая нэг зуун дөчин зургаан мянга хоёр зуун гучин гурван төгрөг наян таван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Б.Амгаланбаяр)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Б.Амгаланбаяр)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

142501011З

1425030026

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ
ᠳ᠂ ᠠᠮᠠᠷᠪᠠᠶᠠᠰᠭᠤᠯᠠᠩ ᠲᠠ

[illegible]

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11.........ны өдрийн А/11... дугаар тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Зооноз өвчин судлалын үндэсний төв

| № | Эд хөрөнгийн нэр | марк дугаар | Ашиглалтанд орсон | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэх үнэ | | Хандив | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Нэр | Эх үүсвэр |
| 2. Машин тоног төхөөрөмж | | | | | | | | | | |
| 1 | Био аюулгүйн кабинатын төхөөрөмж | biobase | 2024 | сайн | ш | 1 | 9,827,525.94 | 9,827,525.94 | Олон улсын атомын энергийн агентлаг | хандив |
| 2 | CR кабинатын төхөөрөмж | biobase | 2024 | сайн | ш | 1 | 4,318,707.91 | 4,318,707.91 | | |
| машин тоног төхөөрөмжийн нийт дүн | | | | | | | | **14,146,233.85** | | |